

## **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Барилга угсралтын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНбад/, Стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ. Барилга угсралтын ажлыг дулааны улиралд хийхээр тооцоологдсон байгаа тул БН ба Д-ийн зохих заалтыг баримтлан гүйцэтгэнэ.

### **Тендерийн бичиг баримтанд заавал бурдуулж ирэх материал:**

- ❖ Барилгын засварын ажил гүйцэтгэх үе шатны график
- ❖ Талбайн зохион байгуулалтын зураглалыг заавал ирүүлнэ.

Бүх үе шатны ажлууд тухай бүрт нь хэмжилт хийж фото зургаар баталгаажуулах, зургийн авторын хяналтыг заавал хийлгэсэн байна.

Барилга угсралтын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ. БН ба Д-ийн зохих заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ.

**Архитектур төлөвлөлт:** Уг барилга нь Сүхбаатар аймгийн Мөнххаан суманд баригдах, сумын ЕБС-ийн спорт заалны барилга. Энэхүү барилга нь зоорьгүй 1 давхар, металл каркасан даацын хийц бүтээцтэй, дулаалгын үетэй ханын болон хучилтын хавтгаалжин сендвичэн хөнгөн хучилт бүхий хийц бүтээцтэй болно. Барилга нь тэнхлэгээрээ 12м x 24м хэмжээтэй байна. Туслах барилга нь 4.2 x 19.31 хэмжээтэй гадна хана нь 10 см-ийн зузаантай хөөснөнцөр дулаалгын үе болон гадна 12 см-ийн өрлөгтэй 38 см-ийн даацын өрлөг бүхий 60 см-ийн зузаантай хана байна.

**Суурийн ажил:** Суурийн нүхийг механизмаар ухаадаа төслийн түвшингээс дээш 20-30см дутуу ухаж түүнээс доош төслийн түвшин хүртэл гараар ухах хэрэгтэй. Барилгын суурь нь цутгамал темэр бетон баганан суурьтай байна. Суурийн дор 10 см зузаан бетон бэлтгэл үе хийж өгнө. Цутгамал төмөр бетон аяган суурийг цутгахын өмнө багана бэхлэх деталийг зургийн дагуу байрлуулж цутгана. Мөн заалны ханын бэхэлгээг шугаман сууринд цутгаж өгнө. Суурийн угсралтын ажлыг эхлэхээс өмнө түүний материалын сорьц шинжилгээг өгч бетоны орцыг тодорхойлсон байх шаардлагатай. Суурийн ажлыг хийх явцад сууринд гарах нүхнүүдийг гаргаж өгсөн байх шаардлагатай, шал довжоон дор хийгдэж широог 20 см тутамд нягтруулсаны дараа бетоны ажлыг гүйцэтгэнэ. Цутгамал суурийн дээд түвшинд хэвтээ ус тусгаарлалтыг шингэн шилний хольцтой, 1:3 харьцаатай 2 см-ийн зузаантай цементэн зуурмагаар хийнэ.

**Багана дам нуруу:** Багана дам нурууг паралель бүстэй двутавр огтполын 30К1, 30Б1, 40Б1 Ст3пс маркийн гангаар гүйцэтгэнэ. Гагнаасанд Э42A төрлийн электрод хэрэглэнэ. Гагнаасын зузааныг гагнагдаж буй элементийн зузаанаас багагүйгээр гаргана.

**Хана:** Заалны ханыг дулаалгатай сендвич хавтангаар хийх бөгөөд зурагт үзүүлсний дагуу төмөр бэхэлгээгээр багананд бэхэлж өгнө. Сендвич ханын зузаан 200мм, туслах байрны ханыг 75 маркийн улаан тоосгоор өрж 50 маркийн цемент шохойн зуурмагаар гагнана. Өргийн барьцал 1.2 кг/м<sup>2</sup>>Rp шаардлагатай. Гадна ханыг нийт уртад нь өргийн өндрийн 675 мм тутамд гадна ханын тор ГХТ-1-ээр арматурлана. Мөн ханын булан уулзвар болон хамар ханыг зурагт үзүүлсний дагуу арматурлана.

**Ялуу:** Угсармал төмөр бетон ялууг цуврал В1. 038-1 дэвтэр 1-ийн дагуу сонгон авлаа. Ялууны нэг талын суулт нь нүхний хэмжээ 1.5 м-с их үед 35 см, 1.1 м хүртэл бол 25см-с багагүй байна. Ялууг жигд тараасан 75 маркийн зуурмаг дээр суулгаж өгнө.

**Хүчилт:** Заалны хүчилтыг дулаалгатай сэндвичин хавтангаар хучиж прогонтой хэвтээ чиглэлд нь 30см-ийн алхамтай боож бэхэлнэ. Туслах барилгын хүчилтыг зургийн дагуу цутгаж хийнэ.

**Хаяавчийн ажил:** Барилгын эргэн тойронд 1 м-ийн өргөнтэй 5-7 см зузаантай 75 маркийн бетон бэлтгэл дээр 2 см зузаан цементэн өнгөлгөөтэй хаяавчийг барилгаас гадагшаа 5%-ийн налуутай хижж өгнө.

**Ялууны ажил:** Гадна болон дотор хананд гаргах нүхнүүд дээр угсармал төмөр бетон ялуу тавина. Угсармал төмөр бетон ялууг цуврал В1.038.-1-ийн дэвтэр 1-ээс сонгов. Ялууны суулт 1.5м-ээс илүү өргөнтэй нүхэн дээр 35см-ээс багагүй, 1.5м хүртэлх нүхэн дээр 25см-ээс багагүй дэрлүүлж суулгана. Угсармал төмөр бетон ялууг 100 маркийн жигд тараасан бэхжээгүй шинэхэн зуурмаг дээр 2 талын суулт жигд байхаар суулгана.

Барилга угсралтын ажлыг 2018 онд барилгын зураг төслийн "Инж кад" ХХК-д боловсруулагдсан 2018 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 982/2018 магадлалын дүгнэлттэй барилгын иж бүрэн зураг төслийн дагуу чанартай барина.

**Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:**

Монгол улсын Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх тохишуулах хугацаа нэг жил байна", 14.6-т "энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолтын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна" гэсэн заалтын дагуу баталгаа гаргаж өгнө.

Барилгын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц хэсэг өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад албан бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ.

Дээрхи техникийн тодорхойлолт заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН  
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА Х.ЭНХЦЭЦЭГ